



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/659

Булган сум

Цагдаагийн газарт дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны хуралдааны III/03 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Зөв дадал-Архигүй орчин” хөтөлбөрийн хүрээнд согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн төвд архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжийн гадна талбайд “Хяналтын камер ажиллаж байна” анхааруулах шар тэмдэг байрлуулахад шаардлагатай 3,300,000 (Гурван сая гурван зуун мянга) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. “Хяналтын камер ажиллаж байна” анхааруулах шар тэмдэг байрлуулахад шаардлагатай 3,300,000 (Гурван сая гурван зуун мянга) төгрөгийг “Зөв дадал-Архигүй орчин” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3. Арга хэмжээг үр дүнтэй, хүртээмжтэй хэлбэрээр чанартай гүйцэтгэж, ажиллахыг Цагдаагийн газар (Г.Ганбаяр Цагдаагийн дэд хурандаа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

